



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 1/22

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/18-11-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, дүнг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар), Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮ (С.Цэдэнсодном) нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010324



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР






### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Дүгнэлт:** Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөдөг, баталдаг нь худалдан авах ажиллагаа удаашрах, төлөвлөсөн хугацаа хэтрэх, он дамжих, хэрэгжихгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх үр дагавартай байна.



**АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот  
2024 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3-3
	Хүснэгтийн жагсаалт	4-4
Нийслэл дэх Төрийн аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс	Хавсралтын жагсаалт	4-4
	Дүрслэлийн жагсаалт	4-4
Хэлтсийн дарга:	Графикийн жагсаалт	4-4
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-5
Аудитын менежер: Э.Мөнхмандах	Ерөнхий мэдээлэл	6-6
	А.1 Төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?	7-12
Ахлах аудитор: Л.Саранбаатар	А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон	7-12
Аудитор:  Д.Дайриймаа	холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?	
	Б.2 Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	13-25
З.Баярбилэгт	Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	13-17
	Б.2.2.Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	17-25
Ц.Ариунболд	В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?	26-30
	В.3.1. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд авсан уу?	26-29
Ч.Чулуун-Эрдэнэ	В.3.2 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	29-30
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	Аудитын дүгнэлт	31-31
Тайланг НТАГ-ын <a href="http://www.audit.mn/">http://www.audit.mn/</a> веб сайтаас үзнэ үү.	Аудитын зөвлөмж	32-32
	Холбогдох байгууллагын санал	33-33
	Саналд өгсөн тайлбар	34-34
	Хавсралтууд	35-54

## Товчилсон үг

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УБ	Улаанбаатар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг Дарга
ЗАА	Захирагчийн ажлын алба
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ХБХГ	Хот байгуулалт хөгжлийн газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НЦХМТГ	Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НОСБГ	Нийслэлийн орон сууцны бодлогын газар
НОСК	Нийслэлийн орон сууцны корпорац
НБОГ	Нийслэлийн байгаль орчны газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
ГУББГ	Геоземи, усны барилга байгууламжийн газар
УБЗЗАГ	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар
ХТГ	Хот тохижилтын газар
ХТСИ	Хот төлөвлөлт, судалгааны институт
УБХАЗТБНТХНэгж	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
УБХГХХОДХ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
УТҮГ	Улсын төсөвт үйлчилгээний газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлчилгээний газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит тооцоот үйлчилгээний газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗҮ	Зөвлөх үйлчилгээ
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТХО	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТББ	Тендерийн баримт бичиг
ТШОЖ	Тендер шалгаруулалтын онцгой журам

### ***Хүснэгтийн жагсаалт***

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
Хүснэгт №1	Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал	7
Хүснэгт №2	Нийслэлийн 2023 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлт	8
Хүснэгт №3	Нийслэлийн 2023 оны төсвийн ТАХ-ний ангилал	9
Хүснэгт №4	Техникийн тодорхойлолтгүй ТАХ	10
Хүснэгт №5	Зураг төсөвгүй ТАХ	10
Хүснэгт №6	Он дамжин болон шилжин хэрэгжиж байгаа ТАХ-д магадлал хийсэн байдал	11
Хүснэгт №7	Зураг төсөв, магадлалын дүгнэлтгүй гүйцэтгэсэн ТАХ	11-12
Хүснэгт №8	Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ	12
Хүснэгт №9	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ	13
Хүснэгт №10	НЗД-н захирамжаар шилжүүлсэн ТАХ	14
Хүснэгт №11	2023 онд хэрэгсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ	18
Хүснэгт №12	Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилт	24
Хүснэгт №13	Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар магадлашгүй, техник хяналт, зохиогчийн хяналтын зардлаар олгосон санхүүжилт	25
Хүснэгт №14	НӨХГ-аас хөрөнгө бүртгэлд тусгасан байдал	26
Хүснэгт №15	Хөрөнгө бүртгэлд тусгасан барилга байгууламжийн ТАХ	26-27
Хүснэгт №16	Хөрөнгө бүртгэлд тусгасан их засварын ТАХ	27

### ***Хавсралтын жагсаалт***

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
Хавсралт №1	Ерөнхий нэрээр баталсан ТАХ-ний жагсаалт	35
Хавсралт №2	Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн богино, дунд хугацааны баримт бичигт нийцээгүй баталсан ТАХ-ны жагсаалт	35-36
Хавсралт №3	Техникийн нөхцөлгүй баталсан ТАХ	36-37
Хавсралт №4	Зураг төсөвгүй батлагдаж, хэрэгжүүлэх шатанд магадлалын дүгнэлт гарч төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ	38-41
Хавсралт №5	Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ	42-43
Хавсралт №6	Шууд захирамжаар ОНӨААТҮГ, төслийн нэгжид эрх шилжүүлсэн ТАХ	44-48
Хавсралт №7	НЗД-н захирамжаар хүчингүй болсон ТАХ-ны жагсаалт	49
Хавсралт №8	ХАА-г 5-10 удаа зохион байгуулсан	50-51
Хавсралт №9	Шаардлага хангаагүй гүйцэтгэгчид	52-54

### ***Дүрслэлийн жагсаалт***

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
Дүрслэл №1	Ерөнхий нэршлээр баталсан	7

### ***Графикийн жагсаалт***

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
График №1	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ	14
График №2	ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр	16

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх</li> <li>○ Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх</li> <li>○ Хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх</li> </ul>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад НЗДТГ, УБ хотын ЗАА, НХААГ, НЗХГ, НОСБГ, НОСК, НГЗБА, ННТГ, “НХОГ”–ОНӨААТҮГ, УБХАЗТБНТХН холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт хамрагдана.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Дайриймаа, аудитор З.Баярбилэгт, Ц.Ариунболд, Ч.Чулуун-Эрдэнэ нар хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитыг 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлүүлж, 2024 оны 6 дугаар сарын 15-нд дуусган, аудитын тайланг НТАГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар батлуулан холбогдох газруудад хүргүүлнэ.</p>

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 115 дугаар тогтоолоор Нийслэлийн 2023 оны төсвийг баталжээ.

Тогтоолын 2, 3, 5, дугаар хавсралтад 2023 онд шинээр хэрэгжих болон өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 1,301,717.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 188 багц ТАХ-г тухайн онд 334,777.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Дээрх 115 дугаар тогтоолд /2023.07.03, 2023.08.09, 2023.11.17/ нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт орж, ТАХ-ний тоо 218 багц, төсөвт өртгийг 1,722,293.6 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүнг 570,388.4 сая төгрөг болгон өөрчилж, тодотгон баталсан байна. Төсвийн тодотголоор 420,576.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 235,611.4 санхүүжих дүнтэй 30 ТАХ нэмэгдсэн байна.

Дээрх 218 багц ТАХ-ээс 678,415.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 95 ТАХ буюу 43.5% нь өмнөх онуудаас хэрэгжиж байгаа, 734,832.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 87 ТАХ буюу 40% нь шилжин хэрэгжиж байгаа ТАХ байна.

Харин 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц ТАХ буюу 16.5% шинээр хэрэгжих ТАХ байна. Тус 36 багц ТАХ-г хэрэгжүүлэх захирамж гаргахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 214 ТАХ болгон хуваажээ. Өмнөх оноос болон шинээр нийт 396 ТАХ-г хэрэгжүүлэхээр байна.

**Худалдан авалт:** НЗД-аас эрх шилжүүлсэн 1,090,337.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 383 ТАХ-ээс 2023 онд 927,902.1 сая төгрөгийн төсөвтэй 349 ТАХ буюу 91.1%-ийн ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

**Гүйцэтгэл:** Нийслэлийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр эхэлсэн нийт 1,229,194.4 төгрөгийн төсөвт өртөгтэй 775 ТАХ-д “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, НЗДТГ, УБ хотын ЗАА ХБХГ, НГЗБА, НЦХМТГ, ННТГ, УБ-Лифт зэрэг 27 газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Үүнээс 2023 онд 309,709.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 518 ТАХ буюу 66.8% нь хэрэгжиж дууссан. Харин 919,485.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 257 ТАХ буюу 33.2% нь дуусаагүй хэрэгжилт дутуу 2024 он дамжин хэрэгжиж байна.

**Санхүүжилт:** Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих болон шинээр хэрэгжих 1,229,194.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 775 ТАХ-нд 2023 онд 570,388.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 538 ТАХ-нд 381,956.5 сая төгрөг буюу 67.0%-ийн санхүүжилт олгожээ.

## А.1 ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

### А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?

“Нийслэлийн 2023 оны төсөв батлах тухай” 2022.12.02-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2023 онд шинээр 56,830.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 багц ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

Төсөв баталсан тогтоолд нэмэлт өөрчлөлтүүд орж анх төлөвлөснөөс 20 багц ТАХ-г нэмэгдүүлж, төсөвт өртөг нь 252,215.3 сая төгрөгөөр нэмэгдэж нийт 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ.

#### Хүснэгт 1. Шинээр төлөвлөсөн ТАХ

№	Ангилал	Тоо	(сая.төг)	
			Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Барилга байгууламж	11	111,382.1	65,476.1
2	Их засвар	11	37,025.7	37,025.7
3	Тоног төхөөрөмж	9	148,215.5	68,303.7
4	Зураг төсөв	3	5,221.7	5,221.7
5	Зөвлөх үйлчилгээ	2	6,200.0	6,200.0
<b>Нийт</b>		<b>36</b>	<b>309,045.3</b>	<b>182,227.2</b>

2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц /214/ ТАХ-нээс 135,989.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ-г нэр байршил нэг бүрээр тусгасан.

Харин 171,705.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих дүнгээр 94,543.6 сая төгрөгийн 14 багц ТАХ-г Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4<sup>1</sup>-дэх заалтыг зөрчиж ерөнхий нэршлээр баталсан байна. Эдгээр 14 багц ТАХ-г хэрэгжүүлэх шатанд НЗД-ын захирамжаар /192 ТАХ/ болгон хувааж, ТАХ-ний төсөвт өртөг, хэрэгжүүлэх байршлыг тодорхойлсон байна. Хавсралт 1 Тухайлбал:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур, ашиглалтын шаардлага хангасан зуух, угаарын хий мэдрэгч. /Улаанбаатар хот/ Төсөвт өртөг:113,400.0 сая төгрөг. НЗД-ын захирамжаар 3 ТАХ болсон;
- “Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн ажил”. Төсөвт өртөг: 4,859.4 сая төгрөг. НЗД-ын захирамжаар 10 ТАХ болсон;
- “Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил”. Төсөвт өртөг:3,000.0 сая төгрөг. НЗД-ын захирамжаар 87 ТАХ болсон;

#### Дүрслэл 1.Ерөнхий нэршлээр баталсан



Эдгээр ТАХ-ээс Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-д 195 буюу 91.1% нь нийцсэн, 19 буюу 8.9% нь нийцээгүй, “Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд 210 буюу 98.1% нь нийцсэн, 4 буюу 25% нь нийцээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4-т заасан “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” шаардлагад нийцээгүй 171,705.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 192 ТАХ, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4-т заасан “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” шаардлагад нийцээгүй 4,097.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ-г 2023 оны төсөвт хэрэгжүүлэхээр тусгасан байна.

НИТХ-ын төсөв баталсан тогтоолоор он дамжих болон шилжин хэрэгжиж буй тодорхой нэр, байршил бүхий төсөл арга хэмжээ төсөвт өртгийг тусгахдаа ТАХ тус бүрээр давхардуулан тусгаж байгаа нь ТАХ-ний нийт төсөвт өртгийг өсгөн харагдуулж байна. Тухайлбал: НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-ний нийт төсөвт өртгийг нэгтгэхэд 1.8 их наяд төгрөг байдлаар харагдаж байгаа ч бодитоор 1.3 их наяд төгрөг байна.

Иймд он дамжих болон шилжин хэрэгжиж буй тодорхой нэр, байршил бүхий төсөл арга хэмжээний төсөвт өртгийг давхардуулахгүй байх асуудлыг анхаарах шаардлагатай байна.

#### Хүснэгт 2. Нийслэлийн 2023 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлт

(сая.төг)

№	Нэр, батлагдсан он, сар, өдөр, дугаар	ТАХ хэрэгжих он	Тогтоолын								
			Батлагдсан			Бодитоор			Өсөлт / бууралт		
			Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн
1	“Нийслэлийн 2023 оны төсөв батлах тухай”	Шинэ	16	56,830.0	46,830.0	16	56,830.0	46,830.0	-	-	-
		Шилжих	87	742,363.9	67,302.2	85	718,121.4	67,302.2	(2)	(24,242.5)	-
		Он дамжих	133	1,004,086.2	220,644.8	87	526,766.2	220,644.8	(46)	(477,320.0)	-
		<b>НИЙТ</b>	<b>236</b>	<b>1,803,280.1</b>	<b>334,777.0</b>	<b>188</b>	<b>1,301,717.6</b>	<b>334,777.0</b>	<b>(48)</b>	<b>(501,562.5)</b>	-
2	2022.12.02-ны өдрийн 115 дугаар “Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай”	Шинэ	36	309,045.3	182,227.2	36	309,045.3	182,227.2	-	-	-
		Шилжих	89	823,746.8	167,516.4	87	734,832.7	167,516.4	(2)	(88,914.1)	-
		Он дамжих	133	1,004,086.2	220,644.8	95	678,415.6	220,644.8	(38)	(325,670.6)	-
		<b>НИЙТ</b>	<b>258</b>	<b>2,136,878.3</b>	<b>570,388.4</b>	<b>218</b>	<b>1,722,293.6</b>	<b>570,388.4</b>	<b>(40)</b>	<b>(414,584.7)</b>	-
	2023.11.17-ны өдрийн 115 дугаар										

#### А.1.1.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох зардлын тооцоолол хийж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлсэн үү?

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8<sup>2</sup>, 6.9<sup>3</sup>-д богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар тусгасан.

Дээрх хуулийн 18.6<sup>4</sup>-д заасны дагуу НИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 29-ны 88 дугаар тогтоолоор “Нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-г баталсан байна.

<sup>2</sup> 6.8. Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.

<sup>3</sup> 6.9. Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц 214 ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд 243,802.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 195 ТАХ буюу 91.1%-ийг нийцүүлсэн, 22,243.1 сая төгрөгийн төсөвт 19 ТАХ буюу 8.9%-ийг нийцүүлээгүй байна.
- “Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 294,546.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ТАХ буюу 98.1%-ийг нийцүүлж, 24,498.8 сая төгрөгийн төсөвт 4 ТАХ буюу 1.9 %-ийг нийцүүлээгүй байна. Хавсралт 2.

**Дүгнэлт:** 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 36 багц 214 ТАХ-нээс хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт дунджаар 94.6%-ийг нийцүүлсэн байна.

### **А.1.1.2 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?**

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4<sup>5</sup>, 4.5<sup>6</sup>, 5 дугаар зүйлийн 5.10<sup>7</sup>-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжих 678,415.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 95 ТАХ, шилжих 734,832.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 87 ТАХ, шинээр хэрэгжүүлэх 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц ТАХ, нийт 1,722,293.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 218 ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор ангилж, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ зэргээр эрэмбэлж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**Хүснэгт 3. Нийслэлийн 2023 оны төсвийн ТАХ-ний ангилал**

ТАХ-ний ангилал	Шинэ			Шилжих			Он дамжих		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	11	112,382.4	65,476.1	79	657,967.4	157,612.1	61	565,430.5	163,346.8
Их засвар	11	37,025.7	37,025.7	3	10,796.4	8,211.0	9	18,800.2	5,722.3
Тоног төхөөрөмж	9	148,215.5	68,303.7	4	64,991.9	1,577.9	14	58,896.3	40,418.1
ТЭЗҮ, зураг төсөв	3	5,221.7	5,221.7	1	1,077.0	115.4	8	32,738.6	8,887.6
Зөвлөх үйлчилгээ	2	6,200.0	6,200.0	-	-	-	3	2,550.0	2,270.0
<b>Нийт</b>	<b>36</b>	<b>309,045.3</b>	<b>182,227.2</b>	<b>87</b>	<b>734,832.7</b>	<b>167,516.4</b>	<b>95</b>	<b>678,415.6</b>	<b>220,644.8</b>

<sup>4</sup> 18.6. Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал аймаг, нийслэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар 01-ний дотор батална.

<sup>5</sup> 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд: .4.4.1 шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл

4.4.2 Их засварын төсөл, 4.4.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл

<sup>6</sup> 4.5 Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

<sup>7</sup> 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1<sup>8</sup>, 67 дугаар зүйлийн 67.3<sup>9</sup>-т заасны дагуу төсвийн төслийг боловсруулах явцдаа 2022 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр иргэдэд нээлттэй хэлэлцүүлэг байдлаар танилцуулсан байна. Мөн [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсаар иргэдэд танилцуулж, санал авахад нийслэлийн 9 дүүргийн 300 гаруй иргэдээс нийт 455 санал ирүүлсэн байна.

**Дүгнэлт:** Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г ач холбогдол, эрэмбэ, дарааллыг баримтлан олон нийтийн саналд үндэслэсэн байна.

### **А.1.1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?**

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган баталж, хэрэгжүүлэхээр заажээ.

Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 309,045.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 багц 214 ТАХ баталсан.

Дээрх 214 ТАХ-ээс 61,365.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 ТАХ-нд техникийн тодорхойлолт шаардлагатай байна. Үүнээс 60,165.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ техникийн тодорхойлолтгүй байна. Хавсралт 3

#### **Хүснэгт 4. Техникийн тодорхойлолтгүй ТАХ**

Техникийн тодорхойлолт шаардагдах			Техникийн тодорхойлолтгүй		
ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
20	60,365.0	59,365.2	13	60,165.2	58,165.2

Барилга байгууламжийн ангилалд 38,412.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ байна. Эдгээр төсөл арга хэмжээнээс магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй баталсан 9,184.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ байна.

#### **Хүснэгт 5. Зураг төсөвгүй ТАХ**

Зураг төсөв шаардагдах			Зураг төсөвгүй		
ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
12	38,412.1	16,949.8	6	9,184.9	9,187.9

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Төсвийн тухай хуулийн 29.4<sup>10</sup>-д заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ээг баталснаас шалтгаалж төсөвт өртөг нь нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөвт ачаалал үүсэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал: Хавсралт 4

- Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 11 байршилд “Цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын 100 ор өргөө” цэцэрлэгийг шинээр барихаар зураг төсөвгүйгээр нэгжийн үнэ 647.3 сая, нийт 7,120.0 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төлөвлөн баталж, хэрэгжүүлсэн. Дээрх ТАХ-нүүдийг хэрэгжүүлэх шатанд магадлалын дүгнэлт баталгаажиж, төсөвт өртөг нь 75.6% буюу 5,389.3 сая төгрөгөөр өсөж, нийт төсөвт өртөг нь 12,509.3 сая төгрөг болсон байна.

<sup>8</sup> 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

<sup>9</sup> 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

<sup>10</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

- Мөн дараах цэцэрлэгийн барилгуудын анхны төсөвт өртөг нь магадлалаар баталгаажсаны дараа 34.8% буюу 10,000.0 сая төгрөгөөр өсөж, нийт төсөвт өртөг нь 28,677.2 сая төгрөг болсон байна

**Хүснэгт 6. Он дамжин болон шилжин хэрэгжиж байгаа ТАХ-д магадлал хийсэн байдал** (сая.төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх огноо	Дуусах огноо	Нийслэлийн 2022 оны төсөв		Нийслэлийн 2023 оны төсөв		Зөрүү		МЕД-ээр хянагдсан төсөв
				НИТХ 2022/111	Гэрээний дүн	НИТХ 2023/115	Гэрээний дүн	Төсөвт өртөг	Гэрээний дүн	
				1	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/	2022	2024	4,500.0	4,352.2	
2	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/	2022	2024	3,220.0	3,220.0	5,867.9	5,867.9	2,647.9	2,647.9	5,867.9
3	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/	2022	2024	4,500.0	4,499.7	5,826.1	5,826.2	1,326.1	1,326.5	5,551.4
4	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19 дугаар хороо/	2022	2024	2,888.3	2,888.3	6,464.3	6,464.3	3,576.3	3,576.3	
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цэцэрлэг)	2022	2024	3,473.8	3,265.1	4,259.8	4,259.8	786.0	994.7	4,259.8
<b>НИЙТ ДҮН</b>				<b>18,582.1</b>	<b>18,225.3</b>	<b>28,677.2</b>	<b>28,677.3</b>	<b>10,095.4</b>	<b>10,452.3</b>	<b>21,938.2</b>

Дээрх ажлууд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжүүлэх шатандаа магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажиж, магадлалын зөрүү дүнгээр дахин гэрээ байгуулж, төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж байгаа нь ЗГ-ын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т заасан “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Мөн “УБЗЗАГ” ОНӨААТҮГ 6,280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г зураг төсөв, магадлалгүйгээр гүйцэтгэж, ажил дууссаны дараа магадлал нь баталгаажсан байна.

**Хүснэгт 7. Зураг төсөв, магадлалын дүгнэлтгүй гүйцэтгэсэн ТАХ** (сая.төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх огноо	Дуусах огноо	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн /2023 он/	Магадлал		Хянагдсан төсөв
						Огноо	Дугаар	
1	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн шинэчлэлт (СБД, Төв шуудангийн уулзвараас урагш Энхтайваны гүүр)	2023	2023	УБЗЗАГ ОНӨААТҮГ	1,524.0	2023.10.30	267/2023	1,525.0
2	Энхтайваны өргөн чөлөөний авто замын нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хэсэгчилсэн засвар,	2023	2023	УБЗЗАГ ОНӨААТҮГ	2,100.0	2023.12.21	366/2023	2,102.2

	шинэчлэлт (5-н шарын уулзвараас Офицеруудын ордоны тойрог)								
3	61 дүгээр сургууль орчмын далан дагасан авто замын засвар, шинэчлэлт (ЧД, 12 дугаар хороо )	2023	2023	УБЗЗАГ ОНӨААТҮГ	855.0	2023.11.16	286/2023	858.4	
4	Сөүлийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт засвар, шинэчлэлт (СБД, 1,2,3 дугаар хороо)	2023	2023	УБЗЗАГ ОНӨААТҮГ	935.0	2023.10.20	255/2023	936.0	
5	Төмөрчиний гудамжны авто замын засвар, шинэчлэлт (ЧД, Жуулчны гудамжнаас Самбуугийн гудамжны авто зам)	2023	2023	УБЗЗАГ ОНӨААТҮГ	866.0	2023.10.20	254/2023	886.3	
	<b>Нийт дүн</b>				<b>6,280.0</b>				

**Дүгнэлт:** ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй ТАХ-г баталснаас шалтгаалж зарим ажлын төсөвт өртөг нэмэгдэж байна.

#### **А.1.1.4 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн уу?**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4<sup>11</sup>-т төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байхаар тусгасан ч 2023 онд хэрэгжиж дуусах 4,097.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ-ний гэрээг 2023 оны 10 дугаар сараас хойш байгуулсан. Хавсралт 5

#### **Хүснэгт 8. Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ**

№	ТАХ-ний ангилал	Эхлэх он	Дуусах он	ТАХ-ний тоо	(сая.төг)	
					Төсөвт өртөг	
1	Засвар	2023	2023	27	3,507.0	
2	Авто зам	2023	2023	1	343.5	
3	Зураг төсөл	2023	2023	5	247.3	
	<b>НИЙТ</b>			<b>33</b>	<b>4,097.8</b>	

Мөн хуулийн 13.1.5<sup>12</sup>-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хууль батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байхаар заасан.

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4 дэх заалтыг зөрчжээ.

<sup>11</sup> 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

<sup>12</sup> 13.1.5. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

## Б.2. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?

### Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

2023 онд НЗД-ын 120 удаагийн захирамжаар 1,090,337,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 383 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг харьяа 28 газарт шилжүүлжээ.

*/Тайлбар:НЗД-аас 36 багц ТАХ-г хэрэгжүүлэх захирамж гаргахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 214 ТАХ болгон хуваасан. Мөн өмнөх онд ХАА зохион байгуулж дуусаагүй 169 нэмэгдэн нийт 383 ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан/.*

Үүнээс 2023 онд 927,902.1 сая төгрөгийн төсөвтэй 349 ТАХ буюу 91.1%-ийн ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

#### Хүснэгт 9. НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ

№	Эрх шилжсэн байгууллага	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ			ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Захирамж	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт
1	БГД	1	1	100.0	-	-	-	-
2	БЗД	1	1	100.0	-	-	-	-
3	БНД	1	1	480.0	1	480.0	475.7	4.30
4	БХД	3	6	741.8	6	741.8	733.2	8.60
5	ГУББГ ОНӨААТҮГ	1	6	1,500.0	6	1,500.0	1,500.0	-
6	Тухай бүр захирамж гараагүй үлдэгдэл	-	7	88,168.7	-	-	-	-
7	ЗХУТ ОНӨААТҮГ	2	6	1,268.3	6	1,268.3	1,268.3	-
8	НГЗБА	3	3	42,512.7	3	42,512.7	36,959.1	5,553.60
9	НД	1	1	500.0	1	500.0	498.9	1.10
10	НЗДТГ	1	2	28,000.0	-	-	-	-
11	НЗХГ	8	20	17,942.7	19	14,742.7	14,515.7	227.00
12	ННТГ	1	1	250.0	-	-	-	-
13	НОСБГ	2	2	3,890.3	1	90.3	90.3	-
14	НОСК	1	2	8,832.8	1	1,987.5	1,896.5	91.00
15	НХААГ	11	69	22,723.2	56	15,338.7	15,146.3	192.40
16	НХААГ, УБАЗТБНТХН	6	2	44,995.2	2	44,995.2	44,305.6	689.60
17	Шилжин хэрэгжих	54	99	687,573.2	99	687,573.2	671,497.5	16,075.70
18	СБД	1	1	100.0	-	-	-	-
19	СХД	2	2	571.3	-	-	-	-
20	УБ Лифт ОНӨТҮГ	1	1	245.8	1	245.8	245.8	-
21	УБЗАА	1	1	23,715.2	-	-	-	-
22	УБЗЗАГ ОНӨААТҮГ	4	136	26,693.4	136	26,693.4	26,693.4	-
23	УБХАЗТБНТХ Нэгж	5	1	77,829.7	1	77,829.7	77,829.7	-
24	УБХГХХОДХ	4	7	9,574.1	7	9,574.1	9,574.1	-
25	УБХХХБШ төсөл	1	1	98.0	1	98.0	98.0	-
26	ХБХГ	1	1	1,522.4	1	1,522.4	1,522.4	-
27	ХТСИ ОНӨААТҮГ	1	1	208.3	1	208.3	208.3	-
28	ХУД	1	1	100.0	-	-	-	-
29	ЧД	1	1	100.0	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>120</b>	<b>383</b>	<b>1,090,337.1</b>	<b>349</b>	<b>927,902.1</b>	<b>905,058.9</b>	<b>22,843.2</b>

Харин 162,435.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 ТАХ тухайн онд хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- 12,701.1 төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ буюу 44.1% нь шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй;
- 33,565.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ буюу 29.4% нь харьяа байгууллагад эрх шилжүүлсэн ч ТББ боловсруулах, үнэлгээ хийх зэргээр тухайн онд бүрэн дуусаагүй;
- 28,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ буюу 5.8% нь худалдан авах ажиллагаа зохион байгуулахад холбогдох харьяа газраас техникийн тодорхойлолт гаргуулах болон дотоодын үйлдвэрлэл судлах зэргээс 2023-2024 он дамжин үргэлжилсэн;

- 88,168.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ буюу 20% нь тухай бүр захирамж гараагүй.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс ТАХ он дамжин хэрэгждэг, ХАА нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй болох, шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгардаг зэрэг зөрчлүүд гарч байна.

### Б. 2.1.1 Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг холбогдох хуульд нийцүүлж зарласан уу?

Дээрх 383 ТАХ-ээс мэргэжлийн байгууллага болох нийслэл, дүүргийн худалдан авах ажиллагааны газар, албанд 22.4% буюу 70,511.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 86 ТАХ-ний эрхийг шилжүүлжээ.

*Тайлбар: Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгийн оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагаа нь хугацааны хувьд 2005 онд батлагдсан /2023.12.31-нд хүчингүй болсон/ ТБОНӨХБАҮХАТХ-ийн үйлчлэлд хамаарч байгаа тул дээрх хуулийг шалгуур үзүүлэлт болгосон.*

График №1 НЗД-аас эрх шилжүүлсэн байдал



Харин харьяа бусад газруудад 1,019,825.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 297 ТАХ буюу 77.6%-ийг шилжүүлсэн. Үүнд: Хавсралт 6

- ОНӨААТҮГ-ууд 29,707.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 ТАХ буюу 39.2%;
- НЗХГ, УБ хотын ЗАА, НОБГ, ННТГ, НОСБГ зэрэг харьяа газрууд 902,408.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 138 ТАХ буюу 36.0%;
- УБ хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж зэрэг газруудад 87,501.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ буюу 2.3%,

### Хүснэгт 10. НЗД-н захирамжаар шилжүүлсэн ТАХ

Д/д	Эрх шилжсэн	ТАХ тоо	Төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн	ТАХ тоо	Төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн
1	ГУББГ ОНӨААТҮГ	6	1,500.0	1,500.0	6	1,500.0	1,500.0
2	ЗХУТ ОНӨААТҮГ	6	1,268.3	1,268.3	6	1,268.3	1,268.3
3	УБ Лифт ОНӨТҮГ	1	245.8	245.8	1	245.8	245.8
4	УБЗЗА ОНӨААТҮГ	136	26,693.4	26,693.4	136	26,693.4	26,693.4
5	УБХАЗТБНТХ Нэгж	1	77,829.7	77,829.7	1	77,829.7	77,829.7
6	УБХГХХХОДХТНэгж	7	9,574.1	9,574.1	7	9,574.1	9,574.1
7	УБХХХХБШ төсөл	1	98.0	98.0	1	98.0	98.0
8	ХТСИ ОНӨААТҮГ	1	208.3	208.3	1	208.3	208.3
	<b>НИЙТ</b>	<b>159</b>	<b>117,417.6</b>	<b>117,417.6</b>	<b>159</b>	<b>117,417.6</b>	<b>117,417.6</b>

НЗД-аас ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байдлыг авч үзвэл 53.5% буюу 205 ТАХ-г 100 хүртэл хоногийн дотор, 46.4%-ийг буюу 178 ТАХ-г 100-аас дээш хоногийн дараа /2023.03.09-2023.12.15/ шилжүүлсэн байна.

ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8<sup>13</sup> дахь заалтыг зөрчин хугацаа алдаж байгаагаас шалтгаалж тухайн ТАХ нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж байна. Тухайлбал:

- НЗД-ын 2023.07.21-ны А/824 захирамжаар НХААГ-т 296.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /барилгын засвар/ 3 ТАХ-ний эрхийг шилжүүлсэн ч 2 ТАХ нь шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүйгээс шалтгаалж тухайн онд дуусаагүй;
- НЗД-ын 2023.08.08-ны А/895 захирамжаар НХААГ-т 488.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /барилгын засвар/ 4 ТАХ-ны эрхийг эрхийг шилжүүлсэн. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах явцад зураг төсөв боловсруулах, ажлын даалгавар батлуулахад цаг хугацаа шаардсан, тендер сонгон шалгаруулалт явагдсан ч шаардлага хангасан оролцогчгүй зэргээс шалтгаалж тухайн онд дуусаагүй;
- НЗД-ын 2023.11.17-ны А/1307 захирамжаар НХААГ-т 5,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах” ажлын ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн;
- НЗД-ын 2023.11.17-ны А/1311 захирамжаар УБ хотын ЗАА-нд 23,715.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм худалдан авах 4 ажлын ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн;
- НЗД-ын 2023.11.30-2023.12.07-ны өдрийн 5 удаагийн захирамжаар 871.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хот тохижилтын 5 ТАХ-ны эрхийг СХД, ХУД, БЗД, БГД-ийн ХААА-нд шилжүүлсэн.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4<sup>14</sup>-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу нийслэлийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, УБ хотын ЗАА болон ИТХ-аас томилсон иргэдийг оролцуулсан байна.

ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2<sup>15</sup>-т заасны дагуу ТАХ-ний ХАА-г Төрийн Худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулжээ.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ баталснаас шалтгаалж худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороодын үйл ажиллагаа зогсох, удаашрах зэргээр үр дүнд нь нөлөөлж байна. Тухайлбал:

- Үнэлгээний хороод байгуулагдан худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад ТАХ-ний газрын зөвшөөрөл, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох баримт материал нь дутуу, боловсруулагдаагүй байсан зэрэг шалтгаанаар нийт 33 ТАХ төсвийн тодотголоор хасагдан хэрэгжихгүй болсон байна. Хавсралт 7

Тендерт оролцогчд нь ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техникийн болон туршлагын шаардлага хангаагүй, зарласан тендер нь оролцогчгүй байсан, зураг, төсөв зөрүүтэй, НЗД-аас цахим системээр эрх шилжүүлээгүй зэрэг шалтгаанаар 43 ТАХ-ний ХАА нь 3-18 удаа зохион байгуулагдсанаас хугацаа хойшлогдож төлөвлөсөн хугацаанд хэрэгжих боломжгүй болсон байна. Хавсралт 8

**Дүгнэлт:** Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төсөвт тусган баталдгаас шалтгаалж ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхэд хугацаа алдах, улмаар ХАА удаашрах, хэрэгжихгүй болох зэрэг эрсдэл үүсэж байна.

<sup>13</sup> 46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

<sup>14</sup> 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

<sup>15</sup> 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

## Б.2.1.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?

Худалдан авах ажиллагаа зохион байгуулан, гүйцэтгэгч сонгон шалгарсан 927,902.1 сая төгрөгийн төсөвтэй 349 ТАХ байна. Эдгээрээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 803,340.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 131 ТАХ-г, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар 2,669.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-г, тендер шалгаруулалтын онцгой журмаар 4,535.0 сая төсөвт өртөгтэй 50 ТАХ-г зохион байгуулжээ. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.12<sup>16</sup>-д хамааруулсан 117,417.6 төгрөгийн төсөвт өртөгтэй 159 ТАХ байна.

Гүйцэтгэгч нь сонгон шалгарсан ТАХ-г төрлөөр авч үзвэл авто зам, барилга байгууламж, засвар 82,7%, төрийн үйлчилгээ 1,4%, хот тохижилт 1,7%, дэд бүтэц 4,3%-г бусад 10,9%-г тус тус эзэлж байна.

График 2 ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр



Аудитын түүвэрт 2023 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 927,902.1 сая төгрөгийн төсөвтэй 349 ТАХ-нээс 121,965.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 212 ТАХ буюу 60.7 хувийг хамруулсан. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан 47,827.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ;
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар зохион байгуулсан 8,626.7 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ;
- Тендер шалгаруулалтын онцгой журмаар зохион байгуулсан 4,532.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ;
- ТБОНӨХБАҮХАТХ-н 3.12-д заасны дагуу НЗД-ын захирамжаар төслийн нэгжүүд болон “ОНӨАТҮГ”-дад эрх шилжүүлсэн 29,900.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 144 ТАХ.

Аудитын түүвэрт хамруулсан ТАХ-нд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

НХААГ болон НЗХГ-аас 15,152.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмын мөрдөөгүй, санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй, ТББ-т тусгасан шаардлага хангаагүй оролцогчдыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан. Хавсралт 9

НЗД-ын 2023.07.07-ны өдрийн А/801 дугаар захирамжаар /ТБОНӨХБАҮХАТХ-н 3.12-т заасныг үндэслэн/ “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-т 26,693.4

<sup>16</sup> 3.12.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 ТАХ-г дүрмээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж үр дүнг танилцуулахыг үүрэг болгосон.

Гэтэл тус газраас “Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт”-ийн 2,185.0 сая төгрөгийн дүн бүхий ажилд “Грэйт роуд” ХХК-тай сонгон шалгаруулалт хийлгүүгээр шууд гэрээ байгуулсан. /2,141.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2023.07.29-ны №230728/АГ-42 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ/

НЗД-ын 2023.08.30-ны өдрийн А/990 дүгээр захирамжаар “ХТГ” ОНӨААТҮГ-т 906.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн.

- Дээрх ажлын хүрээнд УБ хотын ЗАА болон ХТГ-ын хооронд 2023.09.25-ны өдөр “Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-ын гадна зай талбайд учирсан хохирлыг арилгах, сэргээн засварлах” ажлын 29/06-91 дугаар бүхий 493.3 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан. Тус гэрээний 4.2.7<sup>17</sup>-т гэрээгээр хүлээсэн үүргийг бусдад шилжүүлэхгүй байхаар заасан ч ХТГ нь дээрх заалтыг зөрчин “Бумбат даваа” ХХК-тай 420.0 сая төгрөгийн дүн бүхий ажил гүйцэтгэх гэрээ байгуулж гэрээний ерөнхий нөхцөлийг зөрчсөн.
- ХТГ-аас туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа зарим зөрчил гаргасан байна. Тухайлбал: Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороолол, 24 дүгээр байрны зүүн талд хийгдэх гадна талбайн тохижилтын 265.0 сая төгрөгийн дүн бүхий ажилд гүйцэтгэгчээр шалгарсан “Нано Бриллиант констракшн” ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2022.04.27-нд дууссан байхад шалгаруулсан.
- Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, 39 дүгээр цэцэрлэгийн урд талын гадна талбайн тохижилтын 137.7 сая төгрөгийн дүн бүхий ажилд “Прогресс Интермедишн” ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2022.08.30-нд дууссан байхад шалгаруулсан.

НЗД-ын 2023.02.09-ны А/114 дугаар захирамжаар “ЗХУТ”-ОНӨТҮГ-т 1,268.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-г эрх шилжүүлсэн. Гэтэл тус газрын дүрэмд “гадна талбайн бусад тоног төхөөрөмжүүдийн цахилгаан, тэжээл, худаг сувагчлалын засвар арчлалт хийх” талаар чиг үүрэг байхгүй, мөн хариуцах боловсон хүчингүй зэрэг шалтгаанаар 280.0 сая төгрөгийн дүн бүхий ажилд туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна.

НЗД-аас харьяа ОНӨААТҮГ-дад ТБОНӨХБАҮХАТХ-н 3.12-т заасан үндэслэлээр ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нь хамааруулан шилжүүлдэг ч тухайн газруудын ажиллах хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг харгалзаагүйгээс зөрчлүүд гарч байна. Мөн зарим газрын дүрэмд эрх шилжүүлсэн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх чиг үүрэг тусгагдаагүйгээс өөрийн нөөц бололцоогоор хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсэж байна.

Цаашид шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **Б.2.2. Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

Нийслэлийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр эхэлсэн нийт 1,229,194.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 775 ТАХ-д “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, НЗДТГ, УБ хотын ЗАА ХБХГ, НГЗБА, НЦХМТГ, ННТГ, УБ-Лифт зэрэг 27 газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

<sup>17</sup> 4.2.7. Гэрээгээр хүлээсэн эрх үүргийг бусдад шилжүүлэхгүй байх

/Тайлбар: Нийслэлийн төсвийн 2023 онд шинээр хэрэгжсэн 383, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 392, нийт 775 ТАХ./

Үүнээс 2023 онд 309,709.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 518 ТАХ буюу 66.8% нь хэрэгжиж дууссан.

### Хүснэгт 11. 2023 онд хэрэгсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ

(сая төг)

№	ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН	ТАХ-НИЙ					
		Гэрээ байгуулагдсан		Үүнээс			
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Дуусаагүй Гэрээний дүн
1	НАГ	1	159.9	1	159.9	-	-
2	НАОБТГ	-	-	-	-	-	-
3	НБГ	141	5,909.9	141	5,909.9	-	-
4	НБСШТ	1	1,799.9	1	1,799.9	-	-
5	НГЗБА	6	39,801.4	5	38,806.7	1	994.7
6	НЗДТГ	1	84.5	1	84.5	-	-
7	НЗХГ	287	452,653	224	67,339	63	385,314
8	НЗХГ НХОГ	-	-	-	-	-	-
9	НЗХГ, НУБАЗТБНТХН	2	28,989.8	-	-	2	28,989.8
10	ННТГ	2	84,675.4	2	84,675.4	-	-
11	НОБГ	2	172.5	1	100.0	1	72.5
12	НОСБГ	1	90.3	1	90.3	-	-
13	НӨХГ	2	134.2	2	134.2	-	-
14	НТҮГ	1	23,050.0	1	23,050.0	-	-
15	НУБГ НГЗБА	1	350.8	1	350.8	-	-
16	НУБХАЗТБНТХНэгж ОНӨТҮГ	2	3,217.5	1	970.0	1	2,247.5
17	НХБХГ	9	939.7	8	790.0	1	149.7
18	НХОГ	261	537,189.3	83	61,963.0	178	475,226.3
19	НХОГ НХБХГ	1	727.1	-	-	1	727.1
20	НЦХМТГ	13	7,759	12	4,788	1	2,971
21	СХД	11	25,161	5	2,675	6	22,486
22	УБ лифт ОНӨААТҮГ	13	2,050.6	13	2,050.6	-	-
23	УБЗАА	4	2,033	4	2,033	-	-
24	УБХГХХХОДХТНэгж	9	11,574.1	9	11,574.1	-	-
25	УБХХХХБШ төсөл	1	98.0	-	-	1	98.0
26	УСУГ	-	-	-	-	-	-
27	ХБХГ	3	574.7	2	366.5	1	208.3
28	Захирамж гараагүй үлдэгдэл	-	-	-	-	-	-
	<b>НИЙТ</b>	<b>775</b>	<b>1,229,194.4</b>	<b>518</b>	<b>309,709.4</b>	<b>257</b>	<b>919,485.0</b>

Харин 919,485.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 257 ТАХ буюу 33.2% нь дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Хэрэгжилт нь удааширсан ТАХ-ний шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна. Тухайлбал:

#### НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа ТАХ:

- 85 дугаар сургуулийн спорт заалны барилга (УБ хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо) Гэрээний дүн: 1,298.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Голден ийгл стар” ХХК. Зураг төсөвгүй баталсан, барилга баригдах талбайг тодорхой болоогүйгээс хугацаа алдаж хөрөнгө нь он дамжсан. 2023 оны байдлаар газрын асуудлыг шийдвэрлэж, шугам сүлжээний далд ажлууд нь хийгдсэн, улирлын шинж чанараас шалтгаалж технологийн зогсолт хийсэн. Гэрээний хугацааг сунгасан.
- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэг) Гэрээний дүн: 3,199.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Баярсонстракшн ХХК. Зураг төсөвгүй баталсан, 2023 оны байдлаар суурийн ажлыг хийсэн. Гэрээний хугацааг сунгасан.



Тайлбар: 85 дугаар сургуулийн спорт заалны барилгын талбайг бэлтгэсэн байдал



Тайлбар: БЗД 18 хороо 129 дүгээр цэцэрлэгийн суурийн ажил бэлтгэсэн байдал

- Сургуулийн барилга, 640 суудал (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо) Гэрээний дүн: 9,975.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Цамхаг констракшн ХХК. Барилгын суурийн ажил хийгдсэн, дулаан хангамжийн эх үүсвэр нь тодорхойгүй. Гэрээний хугацааг сунгасан.
- Сургуулийн барилга, 640 суудал (Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/ Гэрээний дүн 9,485.8 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жинсний орой ХХК. Газар чөлөөлөлт бүрэн шийдвэрлэгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй. 2023 оны байдлаар Г блокийн суурийн ажил хийгдсэн.



Тайлбар: БЗД, 14 хороо сургуулийн барилга барих, суурийн ажил хийгдсэн байдал



Тайлбар: БЗД, 12 дугаар хороо сургуулийн барилга Суурийн ажил хийгдсэн байдал

- Цэцэрлэгийн барилга, 240 ор (Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо Гэрээний дүн: 5,826.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Бүтээлч трейд ХХК. Газар чөлөөлтийн ажил бүрэн дуусаагүй, барилгын талбайд замын цагдаагийн газрын хуучин бетон хашааг нураагаагүй ажил удаашралтай.
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /СХД, 40 дүгээр хороо/ Гэрээний дүн. 2,637.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Энэрэлт их эрдэнэ ХХК. 2022 онд 512.1 сая, 2023 онд 473.6 сая төгрөгийн санхүүжилт төсөвт тусгаснаас шалтгаалж ажил удааширсан, гэрээний хугацааг сунгасан.



Тайлбар: БЗД, 25 хороо Цэцэрлэгийн барилга барих, барилгын ажил бүрэн дусаагүй, бетон хашаа нураагаагүй байдал



Тайлбар: СХД, 40 хороо барилгын ажил дуусаагүй, хийгдэж байгаа

- Мал эмнэлгийн хяналт, ариутгал халдваргүйжүүлэлтийн байгууламж. /УБ хот, Налайх дүүрэг, 5 дугаар хороо/ Гэрээний дүн: 1,549.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Сутаймандах ХХК. 2022 онд 240.0 сая, 2023 онд 167.5 сая төгрөгийн санхүүжилт төсөвт тусгаснаас шалтгаалж ажил удааширсан, гэрээний хугацааг сунгасан.



Тайлбар: НД, 5 дугаар хороо мал эмнэлгийн хяналт, ариутгалын барилга

### НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа ТАХ:

- Шинээр барих гол замын багц ажлын хүрээнд он дамжин шилжин хэрэгжиж байгаа: Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто замын гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол. Гэрээний дүн: 84,114.1 сая төгрөг. 2022-2023 онд дуусах ажил. Гүйцэтгэгч: Монгол зам групп ХХК болон Ганбүрд ХХК-ийн түншлэл, Газар чөлөөлтийн ажил бүрэн дуусаагүй, нийт 390 нэгж талбай өртсөнөөс 383 нэгж талбарыг чөлөөлж, 7 нэгж талбар үлдсэн. Гэрээний хугацааг сунгасан.
- Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3у/м төмөрбетон гүүрийн барилга. Гэрээний дүн: 15,399.8 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ди Вай Кэй Би ХХК болон Туулын гүүр далай ХХК-ийн түншлэл. 2022-2023 онд дуусах ажил. Тус ажлын хүрээнд 4.27 км урт зам, 14м өргөн зорчих бүхий асфальт бетон хучилттай, 2 талдаа 1.5м өргөн явган замтай байхаар төлөвлөгдсөн. Гэвч авто замын нөлөөлөлд 114 нэгж талбар өртсөнөөс 2022 онд эхний хэсгийг, 2023 онд 54 нэгж талбарыг чөлөөлсөн. Үүнээс шалтгаалж төлөвлөгөөт ажил удааширч, авто замын эхний хэсэгт 2 байршилд нүхэн эвдрэл үүссэн, замын хашлага их хэмжээгээр эвдэрсэн. Гэрээний хугацааг сунгасан.



Тайлбар: Гачууртын уулзвараас шар хадны автобустай холбогдож буй зам

- Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто замын ажил. Гэрээний дүн: 1,213.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: МАЗ ХХК, 2022 онд дуусах ажил. Тус ажлыг гүйцэтгэх гэрээг 2022.07.08-2022.10.31-ний хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажлыг эхлүүлж, 510м хэсэгт борооны ус зайлуулах шугамын ажил, авто замын хуучин хашлагыг авч шинээр солих, явган хүний замын дүүргэлтийн ажил, авто замын хучилтын ажил хийгдсэн. Ажил гүйцэтгэлийн явцад “Ариг гал” ХХК-ийн газар албадан чөлөөлөх захирамжийг эсэргүүцэн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс шалтгаалж гэрээний хугацаа 2024.08.01 хүртэл сунгасан. 2022 онд гүйцэтгэгчид 1,055.6 сая төгрөгийг олгосон.



Тайлбар: Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто замын ажил, газрын маргаантай

**Б.2.2.1 Гүйцэтгэгч нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцүүлэн гэрээний хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэхэд захиалагч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?**

Аудитаар он дамжих болон шинээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдсан 1,229,194.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 775 ТАХ-ний төрөл бүрээс түүвэрлэн 457,542.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 80 ТАХ-г хамруулан газар дээр нь шалгахад зураг төсөвт тусгагдсан ажлууд дутуу хийгдсэн, чанаргүй гүйцэтгэсэн зөрчлүүд илэрлээ. Үүнд:

**НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:**

- Бага тойруугийн зүүн хэсэг, Их сургуулийн гудамж, Ж.Самбуугийн гудамжны зүүн хэсэг, Нэгдсэн үндэстний гудамжны зүүн хэсэгт явган, дугуйн зам шинээр барих болон засвар шинэчлэлт. Төсөвт өртөг: 410.0 сая төгрөг  
Гүйцэтгэгч: УБЗЗАГ ОНӨААТҮГ. Төрийн байгууллагуудын уялдаагүйгээс шалтгаалж МУИС-ын 3-р байрыг шинэчлэн барихтай холбоотойгоор 410.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан замыг эвдэлж гэмтээсэн.



Тайлбар: Бага тойруу, Их сургуулийн шинээр баригдсан замын нөхцөл байдал

- Дараах 4 байршлын ТАХ-ний ажлын даалгаварт “явган хүний замыг өнгөн хавтангаар хийх”-ээр тусгагдсан ч тус байршлуудад явган зорчигчийн хөдөлгөөний эрчим багатай, хучилтыг асфальтаар хийх нь гүйцэтгэх хугацаа багасах давуу талтай гэж үзэн асфальтаар хийж, стандарт мөрдөөгүй байна. Үүнд:
  - Ханын материалын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /СХД, 6 дугаар хороо/. Төсөвт өртөг 2,456.0 сая төгрөг; Гүйцэтгэгч: УБЗЗАГ ОНӨААТҮГ
  - Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны Товчооны замын уулзварын инженерчлэл болон Товчооны замаас урагш хийгдэх авто замын ажил. Төсөвт өртөг 2,500.0 сая төгрөг



Тайлбар: Ханын материалын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт хучилтыг асфальтаар хийсэн байдал



Тайлбар: СХД, Товчооны замаас урагш хийгдэх зам, асфальтаар хийсэн байдал



- 61 дүгээр сургууль орчмын далан дагасан авто замын засвар, шинэчлэлт (ЧД, 12 дугаар хороо). Төсөвт өртөг 855.0 сая төгрөг; явган хүний замыг өнгөт хавтангаар хийхээр тусгасан. Гэвч гүйцэтгэгч нь тус байршилд явган

зорчигчийн хөдөлгөөний эрчим багатай, хучилтыг асфальтаар хийх нь гүйцэтгэх хугацаа багасах давуу талтай гэж үзэн тоо хэмжээг зөрүүлж хийсэн нь стандарт, шаардлагад нийцэхгүй. Авто замын хашлагыг сольсон ч их хэмжээгээр эвдэрсэн.

- Өндөр гэгээн Занабазарын гудамжны авто замын засвар, шинэчлэлт /БГД, Барилгын техникумын зүүн хойд талын замын уулзвараас хойш Гандантэгчилэн хийд/. Төсөвт өртөг 1,080.7 сая төгрөг; явган хүний замын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих налуу нь стандартад нийцээгүй, анхааруулах хавтангаар хийгдээгүй, 2-3 байршилд эвдрэл үүссэн.



Тайлбар: 61 дүгээр сургууль орчмын зам, хучилтыг асфальтаар хийсэн байдал



Тайлбар: Өндөр гэгээн Занабазарын гудамжны авто замын засвар шинэчлэлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих налуу стандартад нийцээгүй



- Дараах 2 байршлын явган хүний замыг хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих чиглүүлэгч хавтанг термопластик материалаар хийсэн, явган хүний замын эхлэл, төгсөгчийг хийгээгүй. Үүнд:

- Зайсангийн гудамж, дугуй цагаан орчим явган, дугуйн зам шинээр барих болон засвар шинэчлэлтийн ажил. Төсөвт өртөг 1,350.0 сая төгрөг.
- Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто зам, БГД, 20-р хороо. Төсөвт өртөг 2,621.9 сая төгрөг.



Тайлбар: Зайсангийн гудамж, дугуй цагааны зам хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих чиглэлийн хавтангүй



Тайлбар: Дунд гол, Алтай хотхоны зам чиглүүлэгч хавтанг термопластикаар хийсэн байдал,

## НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүйгээс барилгын ажлын чанар, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй нөхцөл байдал илэрч байна. Тухайлбал:

- Автобусны зогсоол барьж, тохижуулах ажил (ХУД, 15, 17, 18 дугаар хороо). Төсөвт өртөг: 200.0 сая төгрөг.
  - ХУД 18-р хорооны автобусны буудлын тохижилтын ажил нь зураг төсвөөр саравч нь хажуу хаалт суурьтай байх, анкер суугдсан байхаар тусгагдсан ч тус зургийн дагуу хийгээгүй, гүйцэтгэл дутуу буюу саравчны хажуу хаалт суурилуулагдаагүй, мэдээллийн самбар, хогийн сав хийгдээгүй;
  - ХУД 15-р хорооны тохижилт хогийн сав 1 байхаар тусгагдсан ч суурилуулагдаагүй;

- ХУД 17-р хорооны тохижилтын ажлын байршил тодорхойгүйн улмаас ажил эхлээгүй байна.



Тайлбар: ХУД, 18,15-р хороо автобусны зогсоол барьж, тохижуулсан байдал, хогийн сав суурилагаагүй дугуй байрлуулсан

- Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замыг тохижуулах ажил. Төсөвт өртөг: 1,153.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: ХТГ ОНӨААТҮГ. Тус ТАХ-г гэрээнд зааснаар 2023.12.30-нд хүлээлгэн өгөх ёстой ч тухайн ажил нь 2024 оны 4 дүгээр сарын байдлаар дуусаагүй, ажлын тоо хэмжээ дутуу гүйцэтгэлтэй байна. Үүнд: 39 шон бүхий 49 гадна гэрэлтүүлэг, орчны камер бш, хогийн сав 24 ширхэг дутуу. Мөн дэлбээт сүүдрэвчний дээвэр болон чулуун зам 2-3 хэсэгт эвдэрч хэмхэрсэн.



Тайлбар: Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замыг тохижуулсан байдал

- Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хорооны орон сууцны 1 давхарт байрлах 150 ортой цэцэрлэгийн барилга худалдан авах ажил. Гэрээний дүн: 2,870.0 сая төгрөг. Нийлүүлэгч: Иргэн А.Ганбаатар. Тус барилга нь цэцэрлэгийн зориулалттай биш. Гадна орчин, бүлгийн өрөөний цонх нь стандартад нийцээгүй, гал тогоо болон анги танхимын агааржуулалт муу. Хүүхдийн 00 шаардлага хангаагүй, том жижиг суултууруудтай, өрөө хоорондын хана нимгэн фанераар тусгаарлагдсан, агааржуулалт муутайн улмаас өрөөнүүд чийгтэж дахин засварлах шаардлага үүссэн, цонх стандарт бус онгойгчтой томоор онгойдог хүүхэд унах эрсдэлтэй байна.



Тайлбар: ХУД, 11 хороо орон сууцны 1 давхрын цэцэрлэг агааржуулалт муу, цонх стандартын бус хүүхдийн 00 стандартад нийцээгүй

- 111 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо). Төсөвт өртөг: 1,294.6 сая төгрөг Гүйцэтгэгч: “Бумбод” ХХК. Гэрүүд нь зураг төсөвт 4 талд байхаар тусгагдсан ч газрын байршил хүрэлцээгүй шалтгаанаар 2 гэрийг хооронд нь холбож

барьсан, 1 гэр нь аваарын гарцгүй, агааржуулалт муутай тул нэмэлтээр агааржуулалтын систем хийсэн нь дуу чимээ ихтэй, шалны паркет зай орсон, 00-ын почкиноос ус алддаг.



Тайлбар: Зургийн дагуу баригдаагүй, ослын гарцгүй байдал

- 188 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо). Төсөвт өртөг: 1,139.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Бумбод” ХХК Мембран бүрээс залгаас ихтэй дотор агааржуулалт мөн адил дуу ихтэй.



Тайлбар: Мембран бүрээс тогтосон агааржуулалт систем муу

Цаашид гүйцэтгэгчийн болон захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулж, эвдэрсэн болон дутуу, чанаргүй хийсэн ажлуудыг дахин хийлгэж эргэн мэдэгдэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** 2023 онд хэрэгжиж буй зарим ТАХ-г аудитын түүвэрт хамруулахад зураг төсөвт тусгагдсан ажлууд дутуу хийгдсэн, ажлыг чанаргүй гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

### Б.2.2.2 Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журамд заасны дагуу олгосон уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих болон шинээр хэрэгжих 1,229,194.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 775 ТАХ-нд 2023 онд 570,388.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 538 ТАХ-нд 381,956.5 сая төгрөг буюу 67.0%-ийн санхүүжилт олгожээ.

#### Хүснэгт 12. Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилт (сая.төг)

Д/д	Хөрөнгийн эх үүсвэр	2023/115 дугаар тогтоолоор					Гүйцэтгэл					
		ТАХ тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих		Олгосон	Барьцаа хөрөнгийн дансанд				Алданги	
				Дүн	Хувиар		ТАХ тоо	Дүн	Хувиар	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо
1	Нийслэлийн төсвөөр	603	1,350,430.9	481,251.6	35.6	412	321,312.1	66.8	54	1,635.4	1	0.5
2	Нийслэлийн замын сан	283	203,556.1	89,136.5	43.8	126	60,644.4	68.0	68	2,039.4	1	1.6
	<b>НИЙТ</b>	<b>886</b>	<b>1,553,986.9</b>	<b>570,388.1</b>	<b>36.7</b>	<b>538</b>	<b>381,956.5</b>	<b>67.0</b>	<b>122</b>	<b>3,674.8</b>	<b>2</b>	<b>2.0</b>

Нийт олгосон 538 ТАХ-ний 381,956.5 сая төгрөгийн санхүүжилтээс хэрэгжиж дууссан 122 ТАХ-ний барьцаанд 3,674.8 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

**Хүснэгт 13. Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар магадлашгүй, техник хяналт, зохиогчийн хяналтын зардлаар олгосон санхүүжилт**

(сая.төг)

Д/д	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэл									
		Олгосон		Магадлашгүй ажил		Техник хяналт		Зохиогчийн хяналт		НИЙТ	
		ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн
1	Нийслэлийн төсвөөр	412	321,312.1	13	206.7	109	1,873.4	59	369.4	181	2,449.5
2	Нийслэлийн замын сан	126	60,644.4	14	311.1	87	720.6	-	-	101	1,031.8
	<b>НИЙТ</b>	<b>538</b>	<b>381,956.5</b>	<b>27</b>	<b>517.8</b>	<b>196</b>	<b>2,594.0</b>	<b>59</b>	<b>369.4</b>	<b>282</b>	<b>3,481.3</b>

2023 онд магадлашгүй ажлын зардалд 27 ТАХ-д 517.8 сая төгрөг, техник хяналтын зардалд 196 ТАХ-д 2,594.0 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 59 ТАХ-д 369.4 сая төгрөг нийт давхардсан тоогоор 281 ТАХ-д 3,443.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

НХОГ-аас дараах 3 ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо зөрчил гаргасан байна. Үүнд:

- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга барих (СХД, 26 дугаар хороо)-ны ажил. Гүйцэтгэгч: “Агар дүнг ХХК, Жи Ти менерал майнинг” ХХК-иудын түншлэл, Гэрээний дүн: 4,376.6 сая төгрөг. Концессын гэрээгээр хэрэгжүүлж байсан ТАХ. Захиалагчийн хяналтын зардалд нийт 75.9 сая төгрөгийг авахаар байна. Гэтэл ажлын гүйцэтгэл 9.0%-тай байхад захиалагчийн хяналтын зардалд 45.7 сая төгрөг буюу 60.1%-ийг суутган тооцож урьдчилан авсан байна.
- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор барих (БГД, 3 дугаар хороо, 100 дугаар цэцэрлэг). Гэрээний дүн 3,354.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Баярс констракшн ХХК-ийн Ажил эхлээгүй буюу барилгажилтын талбайд Ф500 шугам таарч зураг төсөв шинээр боловсруулагдаж батлагдаагүй байхад 270.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Дүүргийн нэгдсэн эмнэлгийн их засвар (ХУД, 4 дүгээр хороо). Гэрээний дүн 299.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жи Гоулд ХХК-ийн ТБОНӨХБАУХАТХ-д заасан “барьцаа хөрөнгийн дансанд гэрээний үнийн дүнгийн 5-10%-ийг байршуулж болох” заалтыг зөрчин 148.7 төгрөг буюу 49.7% барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, захиалагчийн хяналтын явцад гардаг, алдаа зөрчлийг таслан зогсоож, шат шатны хяналт, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж эргэн мэдэгдэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** 2023 онд 570,388.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 381,956.5 сая төгрөг буюу 67.0%-ийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

## V. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

### V. 3.1 Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын хүлээн авч, өмчийн бүртгэлд тусгасан уу?

Нийслэлийн ИТХ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.1<sup>18</sup>-т заасны дагуу хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэдэг байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 309,709.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 518 ТАХ буюу 66.8% нь бүрэн хэрэгжиж дууссан.

Үүнээс өмчид бүртгэх барилга байгууламжийн 30,339.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ, их засварын 16,226.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 68 ТАХ, 62,341.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж 34 ТАХ, нийт 81,600.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 81 ТАХ-г тус тус хөрөнгийн бүртгэлд тусгажээ.

Бусад ажлуудын хувьд баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажил үргэлжилж байна.

#### Хүснэгт 14.НӨХГ-аас хөрөнгө бүртгэлд тусгасан байдал

№	Хугацаа	Барилга байгууламж		Их засвар		Тоног төхөөрөмж	
		TAX тоо	Хөрөнгийн дүн	TAX тоо	Хөрөнгийн дүн	TAX тоо	Хөрөнгийн дүн
		(сая.төг)					
1	Он дамжих буюу өмнөх оноос хэрэгжсэн 2023 онд бүртгэлд тусгасан	10	24,673.1	60	15,345.2	1	61,093.7
2	Шинэ буюу 2023 онд хэрэгжсэн 2023 онд бүртгэлд тусгасан	2	5,665.9	8	880.8	33	1,248.6
	<b>НИЙТ</b>	<b>12</b>	<b>30,339.0</b>	<b>68</b>	<b>16,226.0</b>	<b>34</b>	<b>62,341.7</b>

**Барилга байгууламж:** Өмнөх оноос хэрэгжиж дууссан 24,673.1 сая төгрөгийн төсөвт бүхий 10 ТАХ, 2023 онд шинээр хэрэгжсэн 5,665.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-г хөрөнгө бүртгэлд тусгасан байна. Үүнд:

#### Хүснэгт 15.Хөрөнгө бүртгэлд тусгасан барилга байгууламжийн ТАХ

№	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	Бүртгэсэн шийдвэр	Бүртгэсэн огноо	Хөрөнгийн дүн	Бүртгэлд тусгасан байгууллагын нэр	(сая.төг)
1	Цэцэрлэгийн барилга /Багануур дүүрэг, 4 дүгээр хороо, Байдлаг хэсэг/	НИТХ-ын 2023 оны 27 дугаар тогтоол	2023.03.30	1,623.5	БНД-ийн 132 дугаар цэцэрлэг	
2	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтын орон сууцны барилгуудыг дахин төлөвлөж, барилгажуулах	НИТХ-ын 47 дугаар тогтоол	2023.05.01	10,320.5	Нийслэлийн орон сууцны корпорац	
3	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо	НИТХ-ын 2023 оны 72 дугаар тогтоол	2023.06.21, 2023.07.31	1,683.3	СХД-ийн Биеийн тамир, спорт хороо	
4	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар СХД, 26 дугаар хороо/	НИТХ-ын 2023 оны 70 дугаар тогтоол,	2023.06.21, 2023.06.26	520,0	СХД-ийн 260-р цэцэрлэг	
5	"Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 150 ор /Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, 54 дүгээр цэцэрлэг/-ийн ажил"	НИТХ-ын 2023 оны 27 дугаар тогтоол	2023.03.30 2023.05.05	1,439.8	СБД-ийн 54-р цэцэрлэг	
6	Дамбадаржаагийн Цагдаагийн хэлтсийн барилга /СБД/	НИТХ-ын 2023.07.03-ны 89-р тогтоол	2023.03.07	1,453.3	СБД-ийн Цагдаагийн газар	
7	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд цэцэрлэгийн барилга худалдан авах	НИТХ-ын 2023 оны 127 дугаар тогтоол,	2023.12.05	1,500.0	28-р цэцэрлэг	
8	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд орон сууцны 1 давхарт цэцэрлэгийн барилга худалдан авах	НИТХ-ын 2023 оны 127 дугаар тогтоол	2023.12.06	790.0	324-р цэцэрлэг	

<sup>18</sup> Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэнэ.

9	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, орон сууцны 1 давхарт цэцэрлэгийн барилга худалдан авах	НИТХ-ын 2023 оны 127 дугаар тогтоол,	2023.12.07	2,858.0	326-р цэцэрлэг
10	Туул тосгоны Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн барилга	НИТХ-ын 2023 оны 70 дугаар тогтоол	2023.06.21, 2023.06.26	3,198.4	Туул тосгоны Эрүүл мэндийн төв
<b>Нийт дүн</b>				<b>24,673.1</b>	

**Их засвар:** Өмнөх оноос хэрэгжиж дууссан 15,345.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 ТАХ, 2023 онд шинээр хэрэгжсэн 880.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 ТАХ-г хөрөнгө бүртгэлд тусгасан байна. Үүнд:

#### Хүснэгт 16.Хөрөнгө бүртгэлд тусгасан их засварын ТАХ

Д/д	ТАХ нэр	(сая.төг)	Хөрөнгийн дүн
1	Орон сууцны I давхар, 75 ор (Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо)		1,292.00
2	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 280 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо/		4,373.88
3	Барилга, сантехникийн засвар (Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, 2 дугаар сургууль)		147.48
4	Барилга, гадна фасадын засвар (Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо, 119 дүгээр цэцэрлэг)		199.40
5	Барилгын засвар (Баянгол дүүрэг, 6, 18 дугаар хороо, Оюуны ундраа, Эрдмийн өргөө цогцолбор сургууль)		54.53
6	Барилгын засвар (Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, 69 дүгээр сургууль)		97.08
7	Барилга, дээврийн засвар (Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, 70 дугаар сургууль)		101.60
8	Барилга, дээврийн засвар (Баянгол дүүрэг, 8 дугаар хороо, 93 дугаар цэцэрлэг)		115.10
9	Барилга, спорт заалны засвар (Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, 102 дугаар сургууль)		84.60
10	Барилгын дотоод засвар (Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 53 дугаар сургууль)		81.03
<b>НИИТ</b>			<b>6,546.71</b>

**Машин техник, тоног төхөөрөмж:** Нийслэлийн Засаг даргын 2023.08.07-ны өдрийн А/881 захирамжаар “Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд” худалдан авсан нэг бүр нь 272.7 сая төгрөг, нийт 61,093,7 сая төгрөгийн төгрөгийн үнэ бүхий их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 224 ширхэг Хиамен XML6105J15C загварын автобусыг нийслэлийн өмчид бүртгэсэн байна.

Мөн дараах байдлаар ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгажээ. Үүнд:

- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т 33,274.2 сая төгрөгийн үнэ бүхий 122 ширхэг автобус;
- “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т 27,274.0 сая төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг автобус;
- Багануур дүүргийн “Тээвэр зохицуулалтын алба”-нд 545.4 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг автобусыг тус тус хүлээлгэн өгч хөрөнгө бүртгэлд тусгасан байна.

**Дүгнэлт:** 2023 онд холбогдох байгууллагуудын шийдвэрээр барилга байгууламжийн 30,339.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ, их засварын 16,226.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 68 ТАХ, 62,341.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж 34 ТАХ, нийт 81,600.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 81 ТАХ-г хүлээн авч, өмчийн бүртгэлд тусгасан байна.

#### В.3.1.1 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс хууль, журмыг мөрдөж ажилласан уу?

МУ-ын ЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг баталжээ.

Аудитын түүвэрт 20 ТАХ-г хамруулж дээрх дүрмийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрч байна. Үүнд:

Захиалагч болон гүйцэтгэгч талууд комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлт, зөрчил дутагдлыг арилгаж ажлын 14 өдөрт багтаан

биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхээр заасан. Гэтэл дээрх хугацааг хэтрүүлж үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлдэг, комисс нь хугацаа хэтрүүлж ирүүлсэн баримт материалыг хүлээн авч шийдвэр гаргадаг зэргээр дүрмийн 8.1<sup>19</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нэгдсэн эмнэлгийн их засварын ажил. Тус ТАХ-ний үүрэг даалгаврын биелэлт дүрэмд заасан хугацаанаас 4 хоног;
- 85 дугаар цэцэрлэгийн дээврийн их засварын ажил. Тус ТАХ-ний үүрэг даалгаврын биелэлтийг 2 хоног;
- Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай зорьтой 3 давхар, А блок, зорьгүй 4 давхар Б блок, зорьгүй 2 давхар В блок бүхий 960 суудалтай сургууль Тус ТАХ-ний үүрэг даалгаврын биелэлтийг 3 хоног;
- 3х3 сагсан бөмбөгийн талбайн тохижилтын ажил /8 байршилд/. Тус ТАХ-ний үүрэг даалгаврын биелэлтийг 39 хоног;

Мөн 4 ТАХ-ний хувийн хэрэгт комиссын зарим үүрэг даалгаврын биелэлтийг хэрхэн тооцсон талаар тэмдэглэл нь байхгүй байна. Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн “36.1.3.стандартын дагуу баримт бичгийн бүрдэл бүрэн байх” гэснийг зөрчсөн байна.

**Дүгнэлт:** Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

### **В. 3.1.2 Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 165,678.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 212 ТАХ буюу 60.7% нь бүрэн хэрэгжиж дууссан.

**Хөрөнгийн ашиглалт:** Шинээр хүлээн авсан барилга байгууламж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалттай газар дээр нь танилцахад хөрөнгийн үр ашиг нь иргэдэд хүрсэн байна.

Харин дараах хөрөнгийн ашиглалт нь хангалтгүй байна. Үүнд:

- 2022-2023 онд дараах 2 ТАХ-г хэрэгжүүлж нийт 24,130 у/м нэгдүгээр эгнээ тусгаарлах хайс суурилуулж ашиглалтад оруулсан. Үүнд:
  - Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажил. Төсөвт өртөг: 1,000.0 сая төгрөг,
  - Нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хайс тоноглол (Чингисийн өргөн чөлөө, Наадамчдын зам, 7-н буудал, Ард- Аюушийн өргөн чөлөө). Төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг

Дээрх ажлуудын ашиглалтын байдалтай албан тушаалтнуудын хамт газар дээр нь танилцаж уулзалт, ярилцлага хийхэд “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-ын үйлдвэрийн агуулахад 12,166 у/м /962.3 сая төгрөг/ хайс ашиглалтгүй хадгалагдаж байна. Мөн дахин ашиглах боломжгүй, дайрагдаж эвдэрсэн 8,603 у/м /680.5 сая төгрөг/ хайс байна./

<sup>19</sup> 8.1. Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.



Тайлбар: Нийтийн тээврийн нэгдүгээр эгнээ тусгаарлах хайс, тоноглол

- ЗХУТ-ын “Удирдлагын төв дэх серверүүд, программ хангамж, сүлжээ, хамгаалалт”-ын болон бусад тоног төхөөрөмжүүдийн арчлалт хамгаалалтын ажлын хүрээнд 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сүлжээ хангамж, тоног төхөөрөмж худалдан авсан ч 3 нэр төрлийн 32.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ш хатуу диск нь ашиглалтгүй байна.



Тайлбар: Хүлээн авсан тоног төхөөрөмж, хатуу диск

### **В.3.2 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд Нийслэлийн дотоод аудитын алба, НЗДТГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс тусгайлсан болон төлөвлөгөөт шалгалтыг хийж хэрэгжүүлээгүй байна.

Харин хэрэгжүүлэгч байгууллагуудаас хөрөнгө оруулалтын ажлын үе шатны хяналтыг хийж ажилласан ч зөрчлүүд гарч байгаа, хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

#### **В.3.2.1 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?**

2023 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэл, санхүүжилтэд Нийслэлийн Дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Харин НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс хөрөнгө оруулалтын ажлын явцын талаарх мэдээ тайланг 14 хоног тутам холбогдох газруудаас авч нийслэлийн шуурхай хуралдаанд танилцуулж, нийслэлийн удирдлагуудаас цаашид хэрэгжүүлэх чиглэлийг холбогдох байгууллагуудад өгч ажилласан байна.

НХААГ, НЗХГ, НХОГ-уудаас харьяа нэгжийн үйл ажиллагаа болон худалдан авалтын явц, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж ажилласан байна.

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтыг холбогдох байгууллагууд хэрэгжүүлэн ажилласан байна.

### **В.3.2.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгуулсан уу?**

Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” аудитаар нийт 8 зөвлөмж, 3 албан шаардлагыг хүргүүлсэн. Үүнд:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 5 зөвлөмж;
- “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар”, “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар”-т 2 зөвлөмж;
- “Нийслэлийн боловсролын газар”, “Нийслэлийн Замын хөгжлийн газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид төлөвлөлт, эрх шилжүүлэх, худалдан авалт, гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчил арилгуулах тухай НТАГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 352,353,354 дугаартай 3 албан шаардлага хүргүүлсэн.

НЗДТГ-аас 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 03/7640 дугаар албан бичгээр зөвлөмж, албан шаардлагын биелэлтийн хугацааг хоцроож ирүүлсэн.

НХААГ, НЗХГ, НХОГ зөвлөмж биелэлтийг хугацаанд нь ирүүлсэн ч зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Тус аудитаар худалдан авалт, захиалагчийн хяналттай холбоотой зөрчил арилаагүй, дахин давтагдаж байна.

**Дүгнэлт:** Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт хангалтгүй, зөрчил арилаагүй, давтагдаж байна.

---

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

---

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний жагсаалтад төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлуудыг баталсан байна.
2. 2023 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн ТАХ-ээс 91.1%-д нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Гэвч холбогдох газруудаас ХАА зохион байгуулах явцад хууль тогтоомж мөрдөөгүй, ОНӨААТҮГ-ууд нь туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулахад холбогдох журмыг зөрчжээ.
3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлснээс шалтгаалж хөрөнгө оруулалтын ажлууд чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.
4. 2023 онд 538 ТАХ-ний санхүүжилтэд 381,956.5 сая төгрөгийг олгосон байна. Хөрөнгийг барьцаа дансанд төвлөрүүлээгүй, санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслээгүй олгосон зөрчил гарсан нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих шат шатны хяналт хангалтгүйтэй холбоотой байна.
5. ТАХ-г төлөвлөх, худалдан авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг мөрдөөгүй, хариуцан ажиллах, байгууллага, албан тушаалтнууд ажилдаа хариуцлагагүй хандсан, өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд арилгаагүй байна.

---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

---

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Х.Нямбаатар/-д:**

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, батлуулахад ТАХ бүрээр хуульд заасан шаардлагыг бүрэн хангуулж, шат шатны хяналтыг сайжруулж, хариуцлагатай, сахилга баттай байх зарчмыг мөрдөн ажиллах;
2. Төсөл арга хэмжээний худалдан авалт, гүйцэтгэлийн үе шатанд гардаг зөрчил арилахгүй жил бүр давтагдан гарч буй байдалд анхаарал хандуулж, түүнийг таслан зогсоож, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

### **“Нийслэлийн Засаг даргын Тамгын газар”, “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар”-т**

1. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөг болгох;
2. ОНӨААТҮГ-аас хөрөнгө оруулалтын ажилд туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулж байгаа байдал, гэрээ байгуулах явцад хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;
3. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг сайжруулах;
4. Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар төлөвлөгөө гарган биелэлтийг танилцуулах.

### **“Нийслэлийн Замын хөгжлийн газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т**

1. Гэрээний хэрэгжилтийн явцад тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн зөрчлүүдийг таслан зогсоож, стандартын шаардлагад нийцүүлэн засуулж, давтан гаргахгүй байх зөвлөмжийг биелүүлж, хугацаанд нь эргэн мэдэгдэх;
2. Төсөл арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг сайжруулах;
3. Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар төлөвлөгөө гарган биелэлтийг танилцуулах.

# Холбогдох байгууллагын санал




## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас: (976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хуудас: www.ub-procurement.mn

2024.06.06	№	05/1147	
танай	2024.06.03	-ны №	804 -1

### НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус газраас "Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит (НТАГ-2023/28-ШТА-ГА)-ын тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.




## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Нийслэлийн Засаг захиргааны II Байр,  
Цэцэгжидэвч гудамж, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0088  
Утас: (976-11) 32 53 85, Факс: (976-11) 32 44 98  
Цахим шуудан: info@road.ub.gov.mn  
Цахим хуудас: www.road.ub.gov.mn

2024.06.07	№	01/1271	
танай	2024.06.03	-ны №	806 -1

### НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан бөгөөд хүргүүлэх саналгүй болно.




## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ

Бодь цэцэгжидэвч гудамж 9,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-11) 31 16 32, 32 42 49  
Цахим шуудан: Nhog@invest.ub.gov.mn  
Цахим хуудас: www.invest.ub.gov.mn

2024.06.11	№	01/1178	
танай	2024.06.03	-ны №	803 -1

### Санал хүргүүлэх тухай

Танай 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 803 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д, хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна.



---

## Саналд өгсөн тайлбар

---

НХААГ, НЗХГ, НХОГ ОНӨААТҮГ-аас аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд саналаа ирүүлж, цаашид аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн.

НЗД-аас Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд санал ирүүлээгүй.

## Хавсралт

### Хавсралт №1

#### Ерөнхий нэрээр баталсан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл арга хэмжээний нэр	(сая.төг)		
		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Задарсан тоо
1	Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур, ашиглалтын шаардлага хангасан зуух, угаарын хий мэдрэгч (Улаанбаатар хот)	113,400.0	36,238.5	3
2	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлт (Улаанбаатар хот)	500.0	500.0	2
3	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө (Улаанбаатар хот)	12,000.0	12,000.0	12
4	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн ажил (Улаанбаатар хот)	4,859.4	4,859.4	10
5	Гол болон туслах гудамж замын шинэчлэлт	2,400.0	2,400.0	3
6	Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил	13,795.7	13,795.7	12
7	Хотын гол болон туслах гудамж замуудын засвар, арчлалтын ажил	12,000.0	12,000.0	36
8	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажил	1,000.0	1,000.0	6
9	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил	3,000.0	3,000.0	87
10	Гүүр, хоолой, туннелийн засварын ажил	1,000.0	1,000.0	3
11	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт	1,250.0	1,250.0	5
12	Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөл	1,500.0	1,500.0	6
13	Авто зам, замын байгууламжийн барилга, засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөл, зөвлөх үйлчилгээ	1,000.0	1,000.0	4
14	Нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хайс тоноглол болон уулзваруудын дахин инженерчлэл	4,000.0	4,000.0	3
<b>НИЙТ</b>		<b>171,705.1</b>	<b>94,543.6</b>	<b>192</b>

### Хавсралт №2

#### Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино, дунд хугацааны баримт бичигт нийцээгүй баталсан ТАХ-ний жагсаалт

(сая.төг)

##### Богино хугацааны баримт бичиг

Д/д	Төрөл	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Нийслэлийн хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө	
1	Барилга байгууламж	Хүүхдийн амбулатори барилгын гадна дэд бүтцийн ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2023	2023	471.3	471.3	1.1.13	Нийцээгүй /нийгмийн эрүүл мэндийн төвийн үе шаттайгаар байгуулах ажлыг эрчимжүүлнэ. (БЗД)
2	Барилга байгууламж	Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж (Улаанбаатар хот)	2023	2023	250.0	250.0	-	Нийцээгүй
3	Барилга байгууламж	Багахангай үйлдвэрлэл технологийн паркийн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)	2023	2023	62.3	62.3	-	Нийцээгүй
4	Барилга байгууламж	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар хот)	2023	2023	23,715.2	23,715.2	-	Нийцээгүй
<b>Нийт</b>					<b>24,498.8</b>	<b>24,498.8</b>		

Д/д	Төрөл	Төсөл, арга хэмжээний нэр,	Дунд хугацааны баримт бичиг		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
			Эхлэх он	Дуусах он			

		<b>хүчин чадал, байршил</b>		<b>дүн</b>			<b>2020-2024</b>	
1	Барилга байгууламж	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар хот)	2023	2023	23,715.2	23,715.2	5.1.1	Нийцэхгүй /Улаанбаатар ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ/
2	Барилга байгууламж	Нарны гүүрийн баруун тал ДЭМА эмнэлгийн хойд талд хийгдэх авто зам (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2023	2023	2,047.4	730.0	6.3.4.1	Нийцэхгүй /Төмөрбетон гүүрэн байгууламжийг барьж, өргөтгөж, шинэчилнэ/
3	Барилга байгууламж	Гол болон туслах гудамж замын шинэчлэлт	2023	2023	2,400.0	2,400.0	-	Нийцээгүй
4	Барилга байгууламж	Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил	2023	2023	13,795.7	13,795.7	-	Нийцээгүй
5	Зам, засвар	Нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хайс тоноглол болон уулзваруудын дахин инженерчлэл	2023	2023	4,000.0	4,000.0	-	Нийцээгүй
<b>Нийт</b>					<b>45,958.3</b>	<b>44,640.9</b>		

### Хавсралт №3

#### Техникийн нөхцөлгүй баталсан ТАХ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөл, арга хэмжээний ангилал	Эхлэх он	Дуусах он	Төсөөт өртөг	2023 онд санхүүжих дүн (сая.төг)
1	Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур (Улаанбаатар хот), Гэр	Тоног төхөөрөмж	2023	2023	21,000	21,000
2	Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур (Улаанбаатар хот), Байшин	Тоног төхөөрөмж	2023	2023	7,000	7,000
3	Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж (Улаанбаатар хот)	Тоног төхөөрөмж	2023	2023	250	250
4	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар)	Тоног төхөөрөмж	2023	2023	23,715	23,715
5	Тэмдэг	тоног төхөөрөмж	2023	2023	525.0	525.0
6	Хайс	тоног төхөөрөмж	2023	2023	60.2	60.2
7	Тоноглол	тоног төхөөрөмж	2023	2023	194.2	194.2
8	Тэмдэг, тоноглолын арчлалт	тоног төхөөрөмж	2023	2023	100.0	100.0
9	Хурд сааруулагч	тоног төхөөрөмж	2023	2023	80.0	80.0
10	Тэмдэглэл	тоног төхөөрөмж	2023	2023	40.6	40.6

11	Нийслэлийн авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлт	тоног төхөөрөмж	2023	2024	3,200.0	1,200.0
12	<b>Нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хайс тоноглол болон уулзваруудын дахин инженерчлэл</b>	засвар, шинэчлэлт /тоног төхөөрөмж/	2023	2023	3,000.0	3,000.0
13	Нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хайс тоноглол (Чингисийн өргөн чөлөө, Наадамчдын зам, 7-н буудал, Ард-Аюушийн өргөн чөлөө)	засвар, шинэчлэлт /тоног төхөөрөмж/	2023	2023	1,000.0	1,000.0
<b>Нийт дүн</b>					<b>60,165</b>	<b>58,165</b>

**Хавсралт №4**

**Зураг төсөвгүй батлагдаж, хэрэгжүүлэх шатанд магадлалын дүгнэлт гарч төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ**

(сая.төг)

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх огноо	Дуусах огноо	Батлагдсан төсөвт өртөг /НИТХ-ын 2022.12.02-ны өдрийн 111 дугаар тогтоол/	Гэрээний дүн /2022 он/	Батлагдсан төсөвт өртөг /НИТХ-ын 2023.11.06-ны 115 дугаар тогтоол/	Гэрээний дүн /2023 он/	2023 онд олгосон санхүүжилт	Магадлал		
									Огноо	Дугаар	Хянагдсан төсөв
1	165 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо)	2022	2023	647.3	647.3	647.3	647.3	258.9	2023.10.24	1781/2023	1,406.0
2	202 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо)	2022	2023	647.3	647.3	1,205.1	1,205.1	473.7	2023.10.24	1783/2023	1,356.1
3	271 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	2022	2023	647.3	647.3	1,070.6	1,061.9	464.1	2022.12.23	2669/2022	1,061.9
4	188 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	2022	2023	647.3	647.3	1,139.7	1,139.7	585.1	2023.05.25	0708/2023	1,139.7
5	111 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо)	2022	2023	647.3	647.3	1,198.7	1,198.7	289.7	2023.11.16	1962/2023	1,294.6
6	201 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо)	2022	2022	647.3	647.3	647.3	647.3	559.4	2023.10.24	1782/2023	1,383.7
7	297 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 17 дугаар хороо)	2022	2023	647.3	647.3	1,131.6	647.3	258.9	2023.05.17	619/2023	1,131.6
8	6 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 28 дугаар хороо)	2022	2023	647.3	647.3	1,198.6	1,198.6	344.2	2023.04.19	441/2023	1,198.6
9	12 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо)	2022	2022	647.3	647.3	1,190.3	1,190.3	323.7	2023.05.12	597/2023	1,190.3
10	152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Налайх дүүрэг, 1 дүгээр хороо)	2022	2022	647.3	647.3	647.3	647.3	-	2023.08.10	1221/2023	1,347.0

11	164 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо)	2022	2022	647.3	647.3	1,058.5	1,043.5	525.6	2023.04.19	434/2023	1,058.5
12	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/	2022	2024	3,220.0	3,220.0	5,867.9	5,867.9	3,400.0	2023.05.29	723/2023	5,867.9
13	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/	2022	2024	4,500.0	4,499.7	5,826.2	5,826.2	3,626.2	2023.06.08	810/2023	5,551.5
14	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цэцэрлэг)	2022	2024	3,473.8	3,265.1	4,259.8	4,259.8	946.5	2023.06.30	0996/2023	4,259.8
15	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	2022	2024	6,808.4	4,376.7	6,808.4	6,808.4	1,500.0	2022.11.14	2272/2022	6,808.4
16	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Нью Хабитат хороолол/	2022	2024	6,095.1	4,576.3	6,095.1	6,095.1	953.5	2022.11.22	2322/2022	6,095.1
17	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Био комбинат/	2022	2024	6,095.1	4,565.8	6,095.1	4,565.8	910.0	2021.09.24	1431/2021	4,565.8
18	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/	2022	2024	4,500.0	4,352.2	6,259.1	6,259.1	784.7	2023.05.11	580/2023	6,259.1
19	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо/	2022	2024	6,297.0	6,297.0	6,297.0	6,297.0	919.7	2022.11.14	2271/2022	6,297.0
20	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо, Тахилт)	2022	2024	4,757.1	4,757.1	6,285.1	6,285.1	1,300.0	2022.12.01	2409/2022	6,285.1
21	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо)	2022	2024	4,376.6	4,376.6	4,376.6	4,376.6	385.0	2023.04.14	429/2023	6,553.7
22	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 32 дугаар хороо)	2022	2024	4,376.7	4,376.7	4,376.7	4,376.7	250.0	2023.11.01	1836/2023	6,200.2
23	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор (Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо, 234 дүгээр цэцэрлэг)	2022	2023	4,867.0	4,861.6	4,861.6	4,861.6	3,646.2	2023.07.06	1086/2023	4,864.1
24	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо/	2020	2024	13,356.3	4,791.2	13,356.3	4,791.2	400.0	2022.03.01	258/2022	13,356.3

25	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4 дүгээр хороо/	2022	2024	12,000.0	11,982.6	11,982.6	11,982.6	400.0	2024.01.22	90/2024	18,822.6
26	85 дугаар сургуулийн спорт заалны барилга /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/	2022	2024	1,400.0	1,298.0	1,298.0	1,298.0	120.0	2023.07.18	1111/2023	2,282.9
27	Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо)	2022	2024	10,100.0	10,100.0	9,975.3	9,975.3	1,400.0	2023.06.07	0764/2023	11,951.8
28	Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо)	2022	2024	9,723.4	9,705.3	9,720.9	9,705.3	600.0	2023.11.21	1990/2023	13,578.6
29	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /ЧД, 4 дүгээр хороо/	2020	2024	1,459.4	1,459.4	3,351.9	3,351.9	423.2	2022.11.28	2369/2022	3,367.2
30	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил /Улаанбаатар хот, Налайх дүүрэг/	2020	2023	11,524.0	11,524.0	16,289.6	11,524.0	7,500.0	2022.11.03	132/2022	4,765.6
31	Бага тэнгэрийн ам, Туул гол дагуух амралт, зугаалгын цогцолборын тохижилтын ажил, байршил-2 /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	2022	2023	4,150.0	4,150.0	4,476.7	4,476.7	1,783.2	2021.12.15	2027/2021	4,476.7
32	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 42 дугаар хороо/	2020	2024	2,140.9	2,138.6	2,138.6	2,138.6	219.2	2021.04.08	0341/2021	2,140.9
